

УСНЫ КОМПАКТ

Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн туршилт, тохируулгын 2 дугаар шат 6 дугаар сард эхэлж, анхны усаа хүлээн авна



Инженер, техникийн ажилтнууд сургалтад хамрагдаж байна

УСУГ-ын инженер, техникийн ажилтнуудад зориулсан онол, дадлагын сургалт 2025 оны 5 дугаар сарын 3-17-нд УГЦУ-т боллоо. Уг сургалт нь үйлдвэрийн туршилт, тохируулгын дадлагатай уялдан 3 үе шат дуустал үргэлжлэх юм.

Сургалтад цаашид уг үйлдвэрт ажиллах инженер, техникийн 25 ажилтан хамрагдаж байна.

Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн бүтээн байгуулалт, хяналт удирдлагын СКАДА системийн суурилуулалтын ажил 98 хувьд хүрээд байна. Барилга угсралтын ажил дуусаж байгаатай холбогдуулан үйлдвэрийн тоног төхөөрөмжийн туршилт, тохируулгын эхний үе шатыг 2025 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр эхлүүлж, 5 дугаар

сарын 30-нд дуусгалаа.

Тоног төхөөрөмжүүдийн ажиллагааг шалгах туршилт, тохируулгын хоёр дахь үе шат 6 дугаар сард эхлэх бөгөөд энэ үеэр үйлдвэр анхныхаа усыг хүлээж авах юм.

Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн туршилт тохируулга гурван үе шаттай үргэлжилнэ.

Биокомбинатын эх үүсвэрийн 14 худагт насос суурилуулах ажил эхэлсэн бөгөөд 6 дугаар сард багтаан дуусгах төлөвлөгөөтэй байна

Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалт 86%-д хүрлээ

Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх, бохирдлыг бууруулах тухай мэдлэг олгох “Шүүн тунгаая” аяныг эхлүүлээ.


Шүүн Тунгаая



Гурван лабораторид 112 төрлийн 7000 гаруй тоног төхөөрөмж, урвалж бодис нийлүүлнэ



Энэ тухай 4-р нүүрээс уншина уу

ТӨСӨЛ 1. УС ХАНГАМЖИЙН БАРУУН ЭХ ҮҮСВЭРИЙГ ШИНЭЭР БАЙГУУЛАХ ТӨСӨЛ

Төслийн хүрээнд Биокомбинат, Шувуун фабрик орчмын газрын доорх усны ордыг түшиглэн ундны усны хоёр шинэ эх үүсвэр, ус дамжуулах шугам хоолой, дэвшилтэт технологи бүхий Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийг байгуулна. Төсөл хэрэгжсэнээр Улаанбаатар хотын ус хангамж жилд 50 сая орчим шоо метрээр нэмэгдэх юм.



АНУ-ын Сенатын төсвийн хорооны төлөөлөгч Сарита Ванка Мянганы сорилтын II Компакт гэрээ буюу Усны Компактын хүрээнд барьж буй Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлын явцтай 2025 оны 5-р сарын 29-нд танилцлаа.

Ус гүн цэвэршүүлэх урвуу осмосын мембраны тохиргоог шалгаж байна



Монголын Мянганы сорилтын сангийн Ус хангамжийн Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн хүрээнд байгуулж буй Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрт ашиглах урвуу осмосын мембраны тохиргоог шалгах ажил эхлээд байна.

“Баран групп”-ийн гүйцэтгэж буй нийт ажлын гүйцэтгэл 70.24%

“Баран групп”-ийн барилга угсралтын ажлын тухайд Туул гол доогуур 248 м газар микротуннелингийн буюу сүвлэгээний өрөмдлөг хийх ажил 5 дугаар сарын эхээр амжилттай дууссан. Хоёр удаагийн өрөмдлөгөөр нийт 490-ээд метр газар шугам тавьсан. Микротуннелингийн энэ аргачлалаар дахин Биокомбинатын эх үүсвэрийн талбайд хоёр, Шувууны талбайд нэг сүвлэгээг хийж, шугам хоолой тавих юм.



Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн барилгын талбайн ажил

98.31% Үйлдвэрийн гадна талбайн ажил

99.33% Ус гүн цэвэршүүлэх байгууламжийн барилга

95.20% Урвуу осмосын байгууламжийн барилга

99.40% Цэвэршүүлсэн усны сан болон насос станцын барилга

99.20% Тунадас боловсруулах байгууламжийн барилга

99.85% Цахилгаан/генераторын барилга

94.81% Харуулын барилга

100% Түүхий ус дамжуулах хос шугамын угсралтын ажил

90.51% Биокомбинатын цуглуулах шугамын ажил

85.96% Дамжуулах шугамын ажил

90.73% Цэвэршүүлсэн ус дамжуулах шугамын ажил

ТӨСӨЛ 2. ХАЯГДАЛ УС ДАХИН БОЛОВСРУУЛАХ ТӨСӨЛ


Төслийн хүрээнд шинэ Төв цэвэрлэх байгууламжийн дэргэд Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр ("ХУДБУ") болон дахин боловсруулсан усыг "ДЦС-3", "ДЦС-4" ТӨХК-ууд руу дамжуулах системийг барьж байгуулна. Төсөл хэрэгжснээр дулааны цахилгаан станцуудын техникийн усны хэрэглээний 85 хүртэл хувийг дахин боловсруулсан усаар орлуулж, гүний цэвэр усны хэрэглээг жилд 18.0 сая хүртэл шоо метрээр бууруулах юм.

Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалт 86% хүрлээ



100%	Хаягдал ус хүлээн авах худгийн барилга
82.5%	Шахуургын станц №1
83.0%	Тогтворжуулах сан
73.6%	Хөдөлгөөнт био реакторын байгууламж
72.0%	Ламелла тунгаагуурын байгууламж
54.2%	Ширхэгт дүүргэгчтэй шүүлтүүрийн барилга
89.0%	Халдваргүйжүүлэх сан
74.8%	Шахуургын станц №2
52.5%	Ус зайлуулах сангийн барилга
37.7%	Хлор бэлтгэлийн барилга

Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын хүрээнд барьж буй технологийн 9, бусад 8, нийт 17 байгууламжийн барилга угсралтын ажил 86%-ийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна.



Дахин боловсруулсан ус дамжуулах систем, ДЦС-уудын өөрчлөлтийн ажлын явц 76% байна

Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрээс ДЦС-ууд руу ус дамжуулах шугам хоолойн барилга, угсралтын систем байгуулах ажил 76%-ийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна.



- Сүвлэгээ №3 болон №6 буюу ДЦС-уудын хөдөлгөөний эрчим ихтэй авто замд ачаалал үүсгэхгүйгээр машин механизмын түр орц, гарц бэлтгэн шугам хоолойн ажлыг хийж гүйцэтгэсэн.
- Өргөлтийн насос станцаас ДЦС-3 ТӨХК хүртэлх 500м голчтой 2 км шугам хоолойг угсарч суурилуулсан, гүйцэтгэл 87% байна.
- Салаалах худгаас өргөлтийн насос станц хүртэлх 700мм голчтой шугам хоолойн ажлын гүйцэтгэл 61% үргэлжилж байна.

УИХ-ын гишүүд Дахин боловсруулсан ус ашиглахтай холбоотой хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд анхаарна гэв



УИХ-ын даргын 2025 оны 192 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн гишүүд болох УИХ-ын гишүүн Р.Батболд, Д.Жаргалсайхан, Б.Жаргалан, Г.Хосбаяр, Г.Очирбат нар нийслэл хотод хэрэгжиж буй гадаад зээл, тусламжийн төслийн явцтай танилцах хөтөлбөрийн хүрээнд Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлын явцтай танилцлаа.

ТӨСӨЛ 3. УСНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТӨСӨЛ

Усны салбарын хууль эрх зүйн орчин, бодлого зохицуулалтыг сайжруулахад дэмжлэг үзүүлж, салбар байгууллагуудын чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн 5 дэд үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Лабораторийн мэдээллийн удирдлагын систем хөгжүүлэх ажлыг эхлүүллээ



УСУГ-ын Усны төв лаборатори, Үйлдвэрийн хаягдал усны лаборатори болон бусад салбар лабораторид зориулан Лабораторийн мэдээллийн удирдлагын систем (LIMS) боловсруулж хөгжүүлэх гэрээнд Монголын Мянганы сорилтын сангийн гүйцэтгэх захирал Э.Энхгэрэл, “Дижитал Медик” ХХК-ийн захирал М.Амармандах нар 2025 оны 5 дугаар сарын 30-нд гарын үсэг зурлаа. Энэхүү систем нь лабораторийн

дотоод хяналтын үйл явцыг үр дүнтэй удирдах, үйл ажиллагааны урсгалын төлөвлөлт, хэрэгжилтийг оновчтой болгох, шинжилгээний үр дүнгийн нарийвчлал, найдвартай байдлыг хангахад дэмжлэг үзүүлнэ. Мөн шинээр хөгжүүлсэн системийг Усны нэгдсэн мэдээллийн систем (www.ewater.mn)-тэй холбож, шинжилгээний үр дүнг цахим хэлбэрээр дамжуулах, удирдах боломжийг бүрдүүлнэ.

Товчхон



Бүрэн автоматжуулсан 180 ус түгээх байранд Мянганы сорилтын корпорацийн брэндингийн шаардлага хангасан пайз самбарыг байршуулах ажлыг 2025 оны 05 сарын 14-нөөс эхлэн гүйцэтгэж байна.

Бүрэн автомат ус түгээх байрны удирдлагын системийн хэвийн, найдвартай ажиллагааг хангахад дэмжлэг үзүүлэх 24 сарын засвар үйлчилгээний гэрээний төслийг Монголын МСС, УСУГ, “Эйч Ти Эл” ХХК 2025 оны 04-05 дугаар сард хэлэлцэн эцэслэж, гэрээг 2025 оны 05 дугаар сарын 23-нд байгууллаа.

Усны үйлчилгээний үнэ тарифын тогтолцоо, эрх зүйн орчинд хийсэн үнэлгээний үр дүн, холбогдох зөвлөмжийг 2025 оны 5 дугаар сарын 22-ны өдөр Усны зохицуулах хорооны ажлын албаны төлөөлөлд танилцуулж, хэлэлцүүлэг өрнүүлээ.

Гурван лабораторид 112 төрлийн 7000 гаруй тоног төхөөрөмж, тавилга, урвалж бодис нийлүүлнэ

Түрүүч нь 1-р нүүрт

Үйлдвэрийн хаягдал усны бохирдлыг бууруулах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хэсгийн 2022 оны 2 дугаар улирлын хуралдаанаар Компакт гэрээний санхүүжилтээр нийлүүлэх усны чанар шинжлэх лабораторийн тоног төхөөрөмжийг Ус сувгийн удирдах газарт олгохоор шийдвэрлэсэн. Уг ажлын хүрээнд анхан шатны

тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл нийлүүлэх гэрээг “Медимпекс интернэшнл” ХХК, “Грийн химистри” ХХК, “Анун” ХХК-тай байгуулсан бөгөөд эхний ээлжийн багаж, хэмжих хэрэгслийг УСУГ болон Усны газарт нийлүүлж, суурилуулж эхэллээ. Гэрээний дагуу гурван лабораторид 112 төрлийн 7000 гаруй тоног төхөөрөмж, тавилга, урвалж бодис хүлээлгэж өгөх юм.

Нидерландын ус хангамжийн байгууллагуудын мэргэжилтнүүд УСУГ-т ээлжит сургалтаа хийлээ



Усны ашиглалтын байгууллагуудын түншлэлийн хөтөлбөр (WOP)-ийн хүрээнд Нидерландын ус ашиглалтын байгууллагуудын 10 сургагч багш, эксперт мэдлэг туршлагаа хуваалцах зорилготой дөрөв дэх удаагийн сургалтаа 5 дугаар сарын 3-17-нд амжилттай зохион байгууллаа. Энэ удаад байгууллагын манлайлал болон ус хангамж, ариутгах татуургын үндсэн 10 чиглэлээр УСУГ-ын инженер, техникийн ажилтнуудыг чадавхжуулах сургалт хийв.

Сургалтад оролцогчид техникийн үндсэн сэдвүүдээс гадна төслийн удирдлагын сургалт, манлайллын чиглэлээр үнэ цэнтэй мэдлэг, ур чадварыг олж авснаа сургалтын төгсгөлд онцолж байв. Түүнчлэн сурсан мэдсэнээ бусдадаа хуваалцан байгууллагынхаа үйл ажиллагаанд нэвтрүүлж, Улаанбаатар хотын ус хангамж, ариутгах татуургын системийг сайжруулахаар төлөвлөгөө гарган ажиллаж байна.

